

Британий академийн дэд ерөнхийлөгч Петер Браун, Британий Зөвлөлийн хэлтсийн эрхлэгч Джереми Барнетт, тус зөвлөлийн хариуцлагатай ажилтан Бен Кофий нарын зэрэг уулзаж учирсан удирдлагын хүмүүс цөм Англид Монголын судлалыг хөгжүүлэх, англи, Монголын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн харилцаа холбоог өргөтгөх явдлыг чухалчлан дэмжих тухай найрсаг дотно ярилцаж байв.

**НЭГЭН НЭРТ ОТОЧ-ЭМЧ,  
ТҮҮНИЙ БҮТЭЭЛИЙН  
ТУХАЙД**

Н. ДАШЗЭВЭГ

Монголын эртний анагаах ухааны түүхийг судлахад юуны түрүүнд Монгол оронд дэлгэрч байсан бөө мөргөлийн ба шарын шашин болон түүний ихэс лам нарын түүхэн намтар, мөн нэн эртний түүх, археологийн баримт сэлт, угсаатны зүй, үлгэр туульс, ардын аман зохиол зэрэг судлалд тулгуурлан судлаж байдаг байна. Түүний дотор Монголд эртний Энэтхэг, Төвдийн эмнэлэг засал, эм зүйн сургуулийг анх үндэслэн дэлгэрүүлэгчдийн нэг болох ламын гэгээн Лувсанданзанжанцан, Халхын Зая Бандида Лувсанпэрэнлэй, баруун монголын Зая бандида Намхайжанцан нарын үйл ажиллагаа, намтар түүх ихээхэн холбоотой байдаг.

Ялангуяа энэ талаар ламын гэгээн Эрдэнэ бандида Лувсанданзанжанцан бол Монголын анхны ууган оточ-эмчийн нэг болохыг манай улсын түүхэнд дэлгэрэнгүй бичсэн. Лувсанданзанжанцан 11-р жараны шороон туулай жил буюу 1639 оны хаврын эхэн сарын 15-нд Түшээт хааны удмын засаг эрх Чойхүр гэдэг ноёны гэрт Өлзийт Овоо (Одоогийн Өвөрхангай аймгийн Хангай хааны орчим) гэдэг газар төржээ. Тэрээр эцгийн тусламжтайгаар 5 наснаас эхлэн Дашлхүнбо хийдийн Цорж Лувсаняринпилээр 17 нас хүртэл төвд ном заалгаж Өндөр гэгээний багш Бэрэбун хийдийн цорж нялба Намхайсодномдагваас зөвлөлгөө авч байжээ.

Лувсанданзанжанцан 18 настайдаа 1655 онд Төвдийн Лхас (Баруун зуун)-д очиж далай лам, Ванчин-Богд нартай уулзаж, улмаар Гүнбум хийдийн цорж Пэрэнлэйжамц зэрэг 60 гаруй багшаар эртний Энэтхэг Төвдийн их бага арван ухааны номуудыг заалгаж Лхас ба Дашлхүнбод 22 жил суужээ. Тэгээд энэ завсраа анх Төвдөд явахад нь Өндөр Гэгээн тусгайлан захисан ёсоор Анагаах ухаан ба одон орон зурхайн номыг онц сайн сурахыг даалгасан учир анх<sup>1</sup> төвд газрын оточ Гунгаажанчив мөн Лувсандамбадаржаа нараар анагаах ухааны цогт дөрвөн үндэсний ном, мөн түүний хөтөлбөр, судрууд, бас анагаах ухааны олон төрлийн арга заслалын элдэв нэрийн номууд, мэс заслын багаж хэрэгслэлийг эзэмших гарын авлага зэрэг олон номыг заалгаж мэргэжсэн учир Баруун зууд маарамбын дамжаа барьж цол хамгаалж эмчийн хамгийн дээд лхаржи цол хүртжээ. Бас Төвд даяар эмийн хаан 2-р бурхан хэмээгдэх 5-р далай лам Агваанлуvsсанжамцад шавь орж анагаах ухааны бүх номын чухал нууц нэр увьдас, аргыг авч эмийн цогт дөрвөн үндэсний хөтөлбөр, эмийн зүрхэн хураангуй, гэх зэрэг маш олон номуудыг заалгаж, бүрэн сурчээ. Мөн Лувсанданзанжанцан нь төвдөд байх хугацаандаа эмийн номуудыг сайн суралцахын хамт хурал номын аялгуу хөгжим, бурхны бие ба түү-

1. М. Лүнрэгдандар. Монголын эмнэлгийн түүхийн ном, 120 хуудас, Төвд хэлээр

ний оронг бүтээх хэмжээний төрлүүд, бүжиг цам хийх зэрэг үйл ажлуудад онцгой сайн суралцаад нутагтаа 1672 онд буцаж иржээ. Тэгээд нутагтаа ирэхэд нь өөрийн ноёд ихэс лам нар туйлын хүндэтгэн хүлээн авч<sup>2</sup> 1681 онд Бөөрөлжүүт гэдэг газар нэгэн жижиг хийдийг гэлэн Даваасамбуу гэдэг ламаар толгойлуулан байгуулж 60 ламтайгаар уул хийдийг шавь (оточ) өргөл болгон авчээ. Одоогийн Баянхонгор аймгийн Баянзүрх сумын нутаг) Лувсанданзанжанцан нь энэ хийдээ улам өргөтгөн 1685 онд анх манбын дацанг байгуулж бас 1778 оноос эхлэн Лавран, Цогчин, Нүвлин, Шарлин, Гүшиг, Диваажин, Дүйнхор зэрэг найман дацанг Төвдийн Дашлхүнбо хийдийн бүх журам дүрмийг баримтлан байгуулжээ. Тэрээр бас Ордос зэрэг газруудад явж олон сүм хийдийг байгуулж шашин номын үйл хэргийг эрхлэн явуулж онцгой хүчин зүтгэснийг<sup>3</sup> Өндөр гэгээнээ үнэлэн үзэж, 1659 онд Лувсанданзанжанцанд «Эрх дэнэ бандида» цол шагнаж, эрх ямба олгожээ. Мөн түүний сүүлээр бас дахин Өндөр гэгээнээс 1694 онд «Хүрээ хамба номон хаан цол», шар шүхэр шагнаж монголын их хүрээний анхны хамба болгожээ. Бас Монголыг захирах улс төрийн бодлогодоо шарын шашныг ашиглаж оточ Лувсанданзанжанцанд Манжийн эзэн хаанаас 1747 онд мөн Баянзүрх уулын энгэрт Гандан-дэдлин буюу Соёлыг бадруулагч гэдэг нэгэн жижиг хийдийг тусгайлан байгуулж тусгай шавь албат захирах эрх бүхий үнэмлэх бичиг манж, монгол, төвд үсэгтэй мөнгөн тамга сэлтийг олгож, шавийг захирах шанзавтай болгох зэргээр эрх хэмжээг нь нэмэгдүүлж байсныг түүхнээ тэмдэглэжээ.

Ламын гэгээн Лувсанданзанжанцан нь Монгол дахь шарын шашны нөлөө бүхий том төлөөлөгчийн нэг байсан боловч Монголын хуучин анагаах ухааны түүхэнд ул мөрөө үлдээсний хувьд судлууштай зүйл нилээд бий. Жишээ нь: Ламын гэгээн эх нутагтаа ирээд сүм хийд олныг байгуулах ажлын хажуугаар эрдэм ном үзэж, ялангуяа анагаах ухааны талаар шинээр ном зохион бичих, барлаж гаргах, хүн ардыг эмчлэх зэрэг ихээхэн ажлыг хийж байсан ба Монголын эртний Төвд эмнэлгийн анхны нэрт оточ-эмч байсан нь ажиглагдана. Монголын оточ нар Лувсанданзан жанцанг<sup>4</sup> Монголын ууган оточ гэж нэрлэх болсон бөгөөд түүний бичсэн нь эмийн номуудыг манба Дацан сургууль бүхэнд заавал зааж сургах зарчмыг тогтоосон тухай анагаах ухааны доктор Ц. Хайдав нэгэн зохиолдоо тодорхойлжээ. Оточ Лувсанданзанжанцан нь энэ завсраа томхон хэмжээний 5 боть ном зохиосны дотор анагаах ухааны маш сонирхолтой таван төрлийн ном бичсэн бөгөөд энэ нь монгол хүний анх удаа төвд хэлээр бичсэн зохиолын тоонд ордог ба тэдгээр нь түүний сүмбумын бяцхан (А) ботьдод байдаг юм. Үүнд:

— «Анагаах ухааны язгуурын үндэстний тайлбар тодорхой зул gso pa rig pa'i rtza rgyad gy'i 'grel pa gsal pa'i sgron me» гэдэг ном нь анагаах ухааны дөрвөн үндэсний эхний хэсэг «язгуурын үндэс» гэдэг хэсгийг нь тодорхой тайлбарласан ойлгоход амар хялбар бөгөөд мөн анагаах ухааны цогт дөрвөн үндэсний номд гарах бүх бүлэг гарчигуудыг бүрэн тодорхойлж тайлбарласан бөгөөд Монгол хүн анх удаа харь Төвд орны хэлээр чадамгай зохиосон номын нэг юм. Бас анагаах ухааны цогт дөрвөн үндэсний номын гарал үүслийг товлон ойлгоход хялбар болгон тайлбарлахыг оролдсон сонин бүтээл бөгөөд 9x50 см 41 хуудастай. Эд-

2. Гэвш. С. Дашдамбын яриа, Урьд ламын гэгээний хийдэд шавьлан сууж Нүвлин дацанд хурж байжээ.

3. БНМАУ-ын түүхийн 2-р дэвтэр 325-р тал

4. Ц. Хайдав-Дорнодахины анагаах ухааны судар бичгийн тойм. 1975 он 78-79-р тал

гээр нэр дурьдаж байгаа ном судрууд нь ламын өөрийн нутаг болох Арвайхээрийн «Барт» хүрээ буюу Үйзэн вангийн хүрээний ном хэвлэх газарт олон удаа барлагдсан нь одоо Улсын нийтийн номын сан, Ган дан-тэгчлэн хийдийн номын сангуудад олон хувь бий.

«Өвчний язгуурыг номлон тодорхойлсон нь-nad gyi dbye pa'i nam bshad gsal byed» гэдэг ном бол хуучин анагаах ухааны үзлэгээр бүх өвчнийг хий, шар, бадгана, гэдэг гурван том үндсэн хэсэгт хуваадаг. Тийм учраас энэ номонд бүх өвчнийг дээрх гурван хэсэгт ялгаж нэрийг тодорхойлсон учир эмч-оточ нарын онош тавих гарын авлага ном бөгөөд 300-аад төрлийн эмийг найруулан хэрэглэхийг дурьдсаны дээр бас манай орны хангай нурууны орчмоор ургадаг элдэв ургамал, үндэс, навч цэцгийг хэрэглэх талаар тодорхой лавлах байдаг бөгөөд туйлын чухал хэрэгтэй 25 эмийн жорыг багтаасан 9x50 см. 50 хуудастай ном юм.

- «Хамтатгасан туулга эмийн бүлэг. Хүйтэн сэрүүн нийтийг дарах амийн бүлэг. Тасарсаныг залган нийлүүлэх рашаан эмийн бүлэг— bshal la'i sdom lta bu byas pa dang rang pa 'jom kyi spyor pa bdud tzi bcom byed» эдгээр гурван хэсэг эм найруулах тухай энэхүү жижиг зохиол нь 9x50 см 3 хуудастай бөгөөд яс, махны гэмтэл, согог, булчин, шөрмөс, тасрах, мэсийн шарх элдэв буглаа хавдрыг засах зүйлүүдийг дурьдсан сонин ном болой.

- «Увидасын рашааны цацрал-man ngag bdud rtze zags ma» гэдэг ном нь биеийн тэнхээ тамирыг сайжруулах мэдрэлийн ядаргааг сэргээх зэрэг 20 шахам төрлийн эм, тангийн жоруудыг бичсэн бөгөөд 9x50 см 18 хуудастай ном буй. Мөн үүнд: толгой, нүд, чих, ам хамар, хоолойн өвчнүүдэд тусламж үзүүлэх ойр зуурын эмүүд, эмэгтэйчүүдэд олонтай тохиолдох зарим өвчнүүд бас есен төрлийн халууныг ялган эмчлэх ялангуяа балнад зэрэг халдварт өвчнийг эмчлэх тухай гардаг ном болно.

- «Хорин таван эмийн аймаг хэсэг-nyer lnga sde tsang» гэдэг энэ номонд 5-30 хүртэл найрлагатай эм, танг хийх ба эмийн чадал эрдмийн тухай тодорхой өгүүлсэн 9x50 см хуудастай ном болно.

Оточ Лувсанданзанжанцаны анагаах ухааны талаар зохиосон эдгээр сонин номуудыг хойшид манай залуу эрдэмтэн мэргэд сонирхон судалваас Монголын эртний анагаах ухааны хуучин соёлын сан хөмрөгт үнэтэй материалын нэг болон судлагдах зохиол номын дээж билээ. Ер нь Өндөр Гэгээн Лувсанжамбийжанцан, Зая бандида Лувсанпэрэнлэй, ламын гэгээн Лувсанданзанжанцан баруун Монголын Зая бандида Намхай жанцан нар бол Монголын шашин бурханы жинхэнэ төлөөлөгч бөгөөд «амьд бурхан» гэж тахигдсан хүмүүсүүд мөн боловч эртний Монголд ямар ч уналга тээвэр хөгжөөгүй бүдүүлэг бөглүү үед Энэтхэг, Төвд зэрэг алс газар зорьж эрдэм ном бясалгаж Монголын дундад зууны соёлын түүхэнд зохиол бүтээлээрээ багагүй хувь нэмэр оруулсан түүхт хүмүүс бөгөөд тэдний талаар дотоод, гадаадын түүх шаширт тэмдэглэсэн нь олонтай үзэгдэнэ. Манай өвөг дээдсийн үлдээсэн соёлын өвд хамаарагдах тэдгээр зохиол бүтээл нь ялангуяа монгол, төвд зэрэг уламжлалт эм нэлгийг орчин үеийн анагаах ухааны онол практиктай хослуулан судлахад үнэт хэрэглэгдэхүүн болно.